



БАТЛАВ  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАГ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ  
ДАРГА *Д.Монхнасан* д.мөнхнасан

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНЫ 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 06 сарын 23

Залаа овоо

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1. Ухаалаг иргэн**

- 1.1 Ухаалаг иргэн зорилтын хүрээнд нийгэм рүү чиглэсэн, хүн рүүгээ хандсан хандлага өөрчлөх сургалт, үйл ажиллагааг дэмжсэн хөтөлбөр боловсруулан ахмад үе, залуучууд, хүүхэд, бүх иргэдийг хамруулан чадавхжуулна.
- 1.2 Зорилтот бүлгийг иргэдийн орон сууцны төлбөрийг бууруулах, чөлөөлөх хөтөлбөрийг боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх замаар олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон/ орон сууцны хангамжийг нэмэгдүүлж инженерийн хангамжтай орон сууцаар хангана.

**1.3 Эрүүл иргэн**

- 1.3.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны “Жишиг загвар төв” байгуулна.
- 1.3.2 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3.3 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлж, “Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөр, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.4 Эрүүл мэндийг төвийн их засварыг хийлгэнэ.

**1.4 Чанартай боловсрол**

- 1.4.1 Боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.4.2 Цэцэрлэгийн барилгын их засварыг хийлгэж орчин нөхцөлийг сайжруулна.

00000001



- 1.4.3 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.4 Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгож, гэр бүл төлөвлөлтийг сайжруулсан бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 1.4.5 Өрхийг хөгжлийн дэвтэртэй болгож үүгээрээ дамжуулах аз жаргалтай, амгалан гэр бүлийг буй болгоно.
- 1.4.6 Хүүхэд, багачуудын бие даах чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.4.7 Залуучуудын хөгжил төлөвшлийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, идэвхтэй амьдралыг нь дэмжсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4.8 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн хамгаалал, хөгжлийг сайжруулах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.4.9 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хөнгөлөлт өдлүүлэх, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэхэд төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэх журам боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.10 Сурын спортыг хөгжүүлэх, түүхт Хүрэн бэлчир нутгаа хөгжүүлэх зорилгоор Хүрэн 143544 00074 бэлчирт “Сурын спортын цогцолбор” байгуулах.
- 1.4.11 Бага сургуулийн барилгын дуусгалтын ажил хийлгэх.

### **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

- 2.1 Загийн голын төмөр бетонон гүүр барина.
- 2.2 Утаагүй-Баянхонгор төслийг сумандaa хэрэгжүүлж сумын төвийн өрхүүдийг төвлөрсөн дулаан, цэвэр бохирын шугам сүлжээнд холбож орчны бохирдлыг бууруулна.
- 2.3 “Сумын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлж, шинэ гудамж төсөл хэрэгжүүлэн гудамж хорооллыг зам гэрэлтүүлэгтэй болгоно.
- 2.4 Чандмань-Овоо багийг төвийн эрчим хүчинд холбоно.

### **ГУРАВ .ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

- 3.1 Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн “Нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр, төрийн албан хаагчийн “Сургалтын хөтөлбөр”ийг батлуулан хэрэгжүүлэх.
- 3.2 Нутгийн удирдлагын ордон шинээр бариулах.

### **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**




00000002



4.1 Загийн голыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, Түүхийн хөндийд нөхөн сэргээлт хийлгэх.

4.2 Залаа-Овооны хогыг цэвэрлэн, өөр газар хогийн цэг байгуулах.

### **ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ**

5.1 Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэнэ.

5.2 "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлнэ.

5.3 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол малчныг чадавхжуулан малыг эрүүлжүүлнэ.

5.4 Малын чанар, ашиг шимиийг сайжруулна.

5.5 Сайхан тохойд услалтын системтэй болно.

000

23

00000003

